

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/142/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гантулга

Утас: 70432545

цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	Error! Bookmark not defined.
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	16

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ Н.ТУНГАЛАГ
ТАНАА

2021.02.26 № 2/92
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын Аудитын гол асуудал

Шатахуун зарцуулалтын тооцоог анхан шатны хүчин төгөлдөр баримтаар тооцоогүй, спидометрийн заалт баримтлаагүй жолоочийн тооцоог бодож албажуулаагүй, хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй о өртөгтэй их хэмжээний хөрөнгө тайланд тусгагдан олон жил болсон, эмийн нэр төрлийн тооллого хийж тооцоо бодоогүй, эмийн зарлагыг орлогын дарааллаар эрэмбэлээгүй, малын ашиг шим, нас дэвшилт хийгээгүй, зах зээлийн үнээр

021020496

үнэлээгүй, үр дүн, нэмэгдэл хөлсийг хавтгайруулан олгосон зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." , Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,539,601.40</u>	<u>30,494,668.40</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	24,836,965.40	30,494,668.40
351	Түүхий эд материал	11,600,148.00	17,708,451.00
35130	Эм боох материал	11,600,148.00	17,708,451.00
354	Хангамжийн материал	12,126,217.40	11,788,977.40
35410	Бичиг хэргийн материал	824,460.00	776,550.00
35420	Аж ахуйн материал	6,307,583.40	6,413,893.40
35440	Түлш, шатах тослох материал	2,388,000.00	426,000.00
35460	Хүнсний материал	787,100.00	2,353,460.00
35470	Бусад хангамжийн материал	1,819,074.00	1,819,074.00
35600	Мал амьтад	1,110,600.00	997,240.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>363,129,449.63</u>	<u>383,822,920.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	363,129,449.63	383,822,920.14
392	Биет хөрөнгө	327,129,449.63	347,822,920.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	252,136,089.00	266,465,857.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,452,471.04	-12,904,942.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,111,833.00	63,531,833.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,542,583.36	-31,211,222.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,430,668.00	156,555,468.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,071,283.35	-109,649,193.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,362,220.00	19,712,220.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,623,372.62	-6,455,450.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,631,550.00	1,631,550.00
39217	Ном	146,800.00	146,800.00
393	Биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>388,669,051.03</u>	<u>414,317,588.54</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>388,669,051.03</u>	<u>414,317,588.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	388,669,051.03	414,317,588.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,821,565.00	349,821,565.00
51101	Өмч: - төрийн	349,821,565.00	349,821,565.00
512	Хуримтлагдсан үр дүн	-72,323,150.32	-46,674,612.81
51210	Өмнөх үеийн үр дүн	-72,323,150.32	-72,323,150.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,648,537.51

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,170,636.35	111,170,636.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	388,669,051.03	414,317,588.54

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	459,074,779.00	532,017,576.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,380,000.00	445,377,163.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,380,000.00	28,333,795.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,380,000.00	28,333,795.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,380,000.00	28,333,795.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	417,043,368.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	380,313,600.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	36,729,768.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,418,779.00	86,640,413.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,182,700.00	25,498,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,182,700.00	25,498,593.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,441,000.00	28,130,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,441,000.00	28,130,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,795,079.00	33,011,420.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,546,650.00	33,011,420.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	443,717,084.14	506,369,038.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,717,084.14	506,369,038.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,408,149.14	502,964,508.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,075,535.00	298,593,155.00
210101	Үндсэн цалин	263,075,535.00	298,593,155.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,336,440.00	37,153,134.92
210201	Тэтгэврийн даатгал	33,336,440.00	37,153,134.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,495,540.00	27,313,300.00
210301	Гэрэл, цахилгаан	725,840.00	514,800.00
210302	Түлш, халаалт	15,769,700.00	20,798,500.00

210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,150,299.00	57,870,143.00
210401	Бичиг хэрэг	4,199,585.00	3,597,860.00
210402	Тээвэр, шатахуун	26,058,794.00	30,374,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,741,000.00	1,776,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	197,000.00	565,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	21,556,163.00
2105	Нормативт зардал	38,526,522.00	16,052,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,702,922.00	12,113,800.00
210502	Хоол, хүнс	3,823,600.00	3,939,190.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,401,900.00	14,329,768.00
210604	Урсгал засвар	1,401,900.00	14,329,768.00
2107	Томилолт, зочны зардал	2,139,000.00	2,360,400.00
210702	Дотоод албан томилолт	2,139,000.00	2,360,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,876,090.00	1,500,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,399,250.00	822,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	11,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	326,840.00	333,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,406,823.14	47,790,817.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,713,480.00	15,259,720.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,693,343.14	32,531,097.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,308,935.00	3,404,530.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,247,429.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,104,530.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,104,530.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,357,694.86	25,648,537.51
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,357,694.86	25,648,537.51

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	437,694,779.00	466,954,013.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	380,313,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	380,313,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	380,313,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,694,779.00	86,640,413.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,182,700.00	25,498,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,182,700.00	25,498,593.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,441,000.00	28,130,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,441,000.00	28,130,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,795,079.00	33,011,420.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,546,650.00	33,011,420.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	437,694,779.00	466,014,013.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,694,779.00	466,014,013.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,385,844.00	462,609,482.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,800,100.00	290,359,100.00
210101	Үндсэн цалин	180,133,600.00	195,782,700.00
210102	Нэмэгдэл	57,962,800.00	69,091,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	6,600,000.00
210104	Урамшуулал	14,103,700.00	18,884,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,772,595.00	38,554,189.92
210201	Тэтгэврийн даатгал	31,631,404.00	27,394,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,782,502.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,092,792.69
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	523,297.00
210205	Эрүүл мэндийн даатгал	141,191.00	5,761,497.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,402,540.00	25,351,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,922,040.00	514,800.00
210302	Түлш, халаалт	10,480,500.00	18,836,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,656,034.00	37,674,420.00
210401	Бичиг хэрэг	2,799,795.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,359,304.00	30,374,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,496,935.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	53,268,000.00	31,825,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,859,520.00	21,647,085.00
210502	Хоол, хүнс	5,940,480.00	6,680,600.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,468,000.00	3,498,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,927,100.00	19,557,868.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,899,500.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	3,027,600.00	15,557,868.00
2107	Томилолт, зочны зардал	2,130,000.00	2,360,400.00
210702	Дотоод албан томилолт	2,130,000.00	2,360,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,957,335.00	8,983,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,920,495.00	8,304,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	11,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	586,840.00	333,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,472,140.00	7,943,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,472,140.00	7,943,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,308,935.00	3,404,530.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,247,429.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,104,530.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,104,530.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	940,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	940,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	940,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	940,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	940,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-940,000.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-72,323,150.32	388,669,051.03
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-72,323,150.32	388,669,051.03

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-72,323,150.32	388,669,051.03
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,648,537.51	25,648,537.51
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-46,674,612.81	414,317,588.54

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	440,993,800.0	437,410,889.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,993,800.0	437,410,889.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,493,800.0	437,110,889.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,359,100.00	288,359,100.00
210101	Үндсэн цалин	193,782,700.00	193,782,700.00
210102	Нэмэгдэл	69,091,600.00	69,091,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	6,600,000.00
210104	Урамшуулал	18,884,800.00	18,884,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,928,500.00	38,554,189.92
210201	Тэтгэврийн даатгал	27,394,100.00	27,394,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,883,600.00	2,782,502.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,306,900.00	2,092,792.69
210204	Ажилгүйдлийн даатгал	576,700.00	523,297.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,767,200.00	5,761,497.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,902,300.00	25,351,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,057,400.00	514,800.00
210302	Түлш, халаалт	18,844,900.00	18,836,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,690,900.00	37,638,420.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,390,900.00	30,338,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	26,470,600.00	25,635,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,970,600.00	15,963,360.00
210502	Хоол, хүнс	7,000,000.00	6,174,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,498,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,228,100.00	5,228,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00

210604	Урсгал засвар	1,228,100.00	1,228,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,360,400.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,360,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,218,600.00	8,983,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,304,700.00	8,304,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	11,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	333,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6000400.00	5999920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,400.00	5,999,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	440,993,800.0	437,410,899.92
1310	Тусгай зориулалтын шилжүүлгээр	380,313,600.0	377209069.92
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,130,400.00	28,130,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	28,130,400.00	28,130,400.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,549,800.00	32,071,420.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,549,800.00	32,071,420.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18
620003	Үйлчлэх ажилтан	05	05

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
210101	Үндсэн цалин	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	36,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,683,725.00
210502	Хоол, хүнс	506,000.00
210604	Урсгал засвар	14,329,768.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,943,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25498593.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Н.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгах, ашиг шимийн тооцоо хийх, үр дүнгийн урамшуулал, ЭХО, нярайн үзлэгийн нэмэгдэл хэлсний талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 22-наас 2021 оны 02 дугаар сарын 26-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сумынхаа ард иргэдэд мэргэжлийн өндөр түвшинд тэгш хүртээмжтэй, шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлнэ.” гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 443717.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4437.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 506369.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5063.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25648.5 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	702.6	0.00	(702.6)
БАРАА МАТЕРИАЛ	24836.9	30494.6	5657.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	363129.4	383822.9	20693.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	388669.0	414317.5	25648.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0.00	(0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	388669.0	414317.5	25648.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	388669.0	414317.5	25648.5

Оны эхэнд 702.6 мянган төгрөгийн авлага байсныг барагдуулж, тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30494.6 мянган төгрөг болж 5657.7 өссөн нь тайланд онд хүнсний материал тусгай зориулалтын материал нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 363129.4 мянган төгрөг, оны эцэст 383822.9 мянган төгрөг болж 20693.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд 3820.0 мянган төгрөгийн гар компьютер, 12724.8 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, 1350.0 төгрөгийн тавилга эд хогшил, 8904.8 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 62651.9 мянган төгрөг буюу 14 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 39335. мянган төгрөг буюу 13.2 хувь, тогтмол зардал 4817.7 мянган төгрөг буюу 13.2 хувь бараа үйлчилгээний бусад зардал 22384.0 мянган төгрөг буюу 88.1 хувь хангамж бараа материалын зардал 12720.0 мянган төгрөг буюу 28.1 хувиар өссөн, нормативд зардал нь 22473.6 мянган төгрөг буюу 58.3 хувиар буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 440993.8 мянган төгрөгөөр нийт зардлыг 440993.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлан онд улсын төсвөөс 377209.1 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 28130.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 32071.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 437410,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 3104.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дутагдаж байгаа зардалд 5683.7 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ЭМГ –аас авч 5683.7 мянган төгрөгийг холбогдох үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Мөн 1943.1 мянган төгрөгийг тарваган тахлын зардалд, ажилчдын цалин хөлсөнд 2000.0 мянган төгрөг, сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн зардалд 36.0 мянган төгрөг, тарваган тахлын эмч нарын хүнсэнд 506.0 мянган төгрөг, томилолтын зардал 1000.0 мянган төгрөг, эрүүл мэндийн төвийн халаалт засварын зардалд 14329.7 төгрөг нийт 25498,5 төгрөгийг нэмэлт дансаар зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, 7 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 28 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 119015.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 974.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 113058.7 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах 1 албан шаардлага, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 114032.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 974.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 113058.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1.Эмнэлгийн албаны машины жолоочийн тооцоо бодож албажуулаагүй,машины спидометрийн заалтыг баримтлаагүй,иж бүрдэл дутуу замын хуудсаар тооцоо хийж шатахуун зарлагадсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 37.1.7-д"төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" ,Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтууд, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Эмийн нэр төрлийн тооллого хийж тооцоо бодож баталгаажуулаагүй,өмнөх оноос эмийн үлдэгдэл их хэмжээгээр өссөн, 87 нэр төрлийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөнийг дахин үнэлээгүй, эдгээрээс 12 нэр төрлийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн, дуудлагын бүртгэлийн журнал, жолоочийн тооцооны хуудсаар бичигдсэн шатахуун нярвын тайлангаар зарлагадсан шатахуун зөрүүтэй зэрэг зөрчил нь Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д"Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах",20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" хуулийн заалт, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны нэгдсэн сайтын тулгалтаар дараа жилийн төсвийн төсөл, төсвийн байгууллагын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, худалдан авах ажиллагааны тайлан бүтэн жилээр, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ". 8 дугаар зүйлийн 8.1, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтууд Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Үр дүн, цалингийн нэмэгдлийг ажлын үр дүнг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас

өмнө хянан, баталгаажуулах", 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын "З" дахь заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", ЗГ-ын 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, их эмч нарт ЭХО, болон нярайн үзлэгийн нэмээдлийг олгохдоо үзлэгт хамарсан иргэдийн тоо, оношилгоо, үзлэгийн үр дүн зэргийг үнэлж дүгнэсэн үзүүлэлтээр хувь тогтоож байх

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. **Балансын данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Байгууллагын малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй хямд үнэтэй дансанд бүртгэгдсэн, ашиг шим, нас дэвшилтийн тооцоо хийгээгүй олон жил болсон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтууд зөрчсөн байна.

2.2 Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Алтай сумын Эрүүл мэндийн төв	Аудитын код:
2021			ХОА-2021/142/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5

1	Эмнэлгийн албаны машины жолоочийн тооцоо бодож албажуулаагүй, машины спидометрийн заалтыг баримтлаагүй, иж бүрдэл дутуу замын хуудсаар тооцоо хийж шатахуун зарлагадсан	974.2	Төлбөрийн акт	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Н.Тунгалаг А.Нямаа
2	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Албан шаардлага		
3	Хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглагдах боломжгүй хөрөнгө тайланд бүртгэлтэй олон жил болсон	81704.0	Албан шаардлага		
4	Дуудлагын бүртгэлийн журнал, жолоочийн тооцооны хуудсаар бичигдсэн км-ийн шатахуун, нярвын тайлангаар зарлагадсан шатахуун зөрүүтэй	13646.3	Албан шаардлага		
5	Эмийн нэр төрлийн тооллого хийж тооцоо бодож баримтжуулж баталгаажуулаагүй, эмийн зарлагын дарааллын эрэмбийг баримтлаагүй, өмнөх оноос эмийн үлдэгдэл их хэмжээгээр өссөн.	17708.4	Албан шаардлага		
6	Байгууллагын малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй хямд үнэтэй дансанд бүртгэгдсэн, ашиг шим, нас дэвшилтийн тооцоо хийгээгүй.	997.2	Зөвлөмж өгөх		
7	Их эмч нарт ажил хавсран гүйцэтгэсний хөлс болох ЭХО, нярайн үзлэгийн нэмэгдлийг ажлын үзүүлэлт, үр дүнгээр олгоогүй	3985.8	Зөвлөмж өгөх		
8	Үр дүнгийн урамшууллыг олгохдоо ажилтнуудын ажлыг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон.	0	Зөвлөмж өгөх		
Дүн		119015.9			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Огноо: 2021. 02.26

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо: 2021. 02.26

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.ГАНТУЛГА

Огноо: 2021. 02.26